



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/332

Мөрөн сум

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.1, 48.6 Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 1-р багт “Монгол-Солонгосын Ногоон Хэрэм төсөл”-ийн хүрээнд баригдсан 10/04кВ-ын 100Ква дэд станцын ажлыг хүлээж авах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Энхжаргал
(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд: Ж.Жавзанпагма
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Д.Аюушжав
(Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

Б.Батлхагва
(Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн хяналтын инженер)

Л.Бямбасүрэн
(Аймгийн онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:
Б.Мөнхбаатар
(“Хөвсгөл Эрчим хүч” ХХК-ийн дотоод хяналтын албаны дарга)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:
Н.Мөнхгэрэл
(“Ногоон хэрэм төсөл”-ийн менежер)

Комиссын нарийн бичгийн дарга:

Б.Баасанжав

(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын
мэргэжилтэн)

2. Барилга байгууламжийн ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Барилга байгууламжийн ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Б.Баасанжав) -д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга байгууламжийг хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН